



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 4/622

Хэрлэн сум

Мал тэжээвэр амьтад,
хашаа, худгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 7-оос 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд явуулсугай.

2.Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн 2024 оны жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Б.Өнөрцолмон	Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга:	Г.Сэдэдмаа	Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн Дарга:	Ц.Батхишиг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүдэд:	Н.Үнэнбат	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Г.Гантөмөр	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч
	А.Гантөмөр	Татварын газрын дарга
	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

2.

Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга
Б.Хэрлэнчимэг	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
Б.Энхболор	Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга


3.Жилийн эцсийн мал тооллогын холбогдох зардлыг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Жилийн эцсийн мал тооллогын хяналтын зардалд зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

5.Мал тооллогын хяналтад зарцуулах 5,616,000 (таван сая зургаан зуун арван зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.

6.Жилийн эцсийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, сумдын ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, чанартай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлыг хэсгийн ахлагч (Б.Өнөрцолмон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

12 дугаар сарын 05
Аймгийн Засаг Д...
дугаар захирамжийн хавд...

Хэнтий аймгийн жилгийн эцсийн мал тооллогын хяналтын ажлаар д
комиссын гишүүдийн хөдөө орон нутагт ажиглах томилолт шатахууны зардал

	Томилголтоор ажилглах албан хаагч	Томилголтоор ажилглах сумын тоо	Нэг суманд ажилглах хоног 2 өдөр /нэг хоногийн томилголт 90,000 төгрөг/
АЗДТГазар	Засаг даргын орлогч	2	360000
	Жолооч	2	360000
	Хэлтсийн дарга	3	540000
	Мэргэжилтэн	3	540000
Статистикийн хэлтэс	Жолооч	3	540000
Нийт дүн			2340000

2. Шатахууны зардал

Комиссын шатахууны зардал	Хяналт хийх сумын тоо	Хяналт хийх өрхийн тоо /1 суманд 20 өрх/	Өрх хооронд 25 км	100 км-т зарцуулах шатахуун / литр/	Зарцуулах шатахуун бүгд /литр/	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
	8	160	4000	20	800	2520	2016000
	5	100	2500	20	500	2520	1260000

Нийт төсөв

5616000